

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМАНД 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
БАЙДЛААР ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ
ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

Тус яам, иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх ажиллагааг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж байна.

2017 онд нийт хүлээн авсан өргөдөл, гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал, зохион байгуулж хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай мэдээ, танилцуулгыг тогтоосон журам, хугацааны дотор гаргаж, Сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулан дүгнэлт, шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Тус яаманд 2017 онд нийт **383** өргөдөл ирсэнээс хуулийн хугацаанд **363** өргөдлийг шийдвэрлэж бусад байгууллагад **121** иргэний өргөдлийг шилжүүлсэн, **99** иргэний өргөдлийг хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн, **20** өргөдөл хугацаа болоогүй /хяналтад/ байна. Нийт өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн биелэлт **94,7%** хэрэгжилттэй байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар хүлээн авч, шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын талаарх тайланг ЗГХЭГ-ын 2014 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 548 тоот албан бичгийн дагуу хавсралт 1,2,3-аар тус тус гарган хүргүүлж байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

.....тоот албан бичгийн
нэгдүгээр хавсралт

**Эрчим хүчний яаманд 2017 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс
Төрийн захиргааны байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтанд
хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт	Үүнээс:				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар хандсан	Биечлэн уулзсан	Бусад
1	Эрчим хүчний яам	383	374	9	0	0	0
Тайлбар: 11-11төвөөс шилжиж ирсэн санал хүсэлтийг тайланд оруулаагүй болно. 2017 оны 12 сарын 28-ний байдлаар							

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

.....тоот албан бичгийн
хоёрдугаар хавсралт

**Эрчим хүчний яаманд 2017онд иргэдээс Төрийн захиргааны
байгууллага, аж ахуй нэгж, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл,
гомдлын шийдвэрлэлтийн байдал**

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл гомдлын тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж /сунгаж/ шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Эрчим хүчний яам	383	363	121	99	20	94,7%

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

Өргөдөл, гомдол санал хүсэлтийн агуулга

д/д	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал / тоо, нийт өргөдөл гомдолд эзлэх хувь /
1	Эрчим хүчний яам	<p>Нийт 383 өргөдлөөс: Хүсэлт – 301/78,5% Гомдол – 70/18,2% Санал – 12 / 3,1%</p> <ul style="list-style-type: none"> • Түлш эрчим хүчний үйлдвэрлэлттэй холбоотой -157 /40,9% • Ажилд орох, гарах, чөлөө хүсэх, цалин хөлс,тэтгэвэр тэтгэмж, зэрэг төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл баталгаатай холбоотой асуудлаар – 150 /39,1% • Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой – 65 / 16,9% • Бусад асуудлаар- 11 /2,8% <ul style="list-style-type: none"> ✓ Иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах ажлыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна. ✓ Нийслэлийн гэр хорооллын цахилгаан шугам сүлжээ, дэд станцыг өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэхэд шаардагдах 20000 айл өрхийг 4.0 кВт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бүрдүүлэх 28 багц ажлыг хэрэгжүүлэхээр холбогдох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. ✓ Нийслэлийн агаар, орчны бохирдлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Эрчим хүчний хэрэглээний шөнийн тарифыг тэглэх шийдвэр гарч 2017 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн. - Нийслэлд ажиллаж байгаа 68 халаалтын зуухыг зогсоож, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох ажил. - Цахилгаан дамжуулах сүлжээ, дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн барилга угсралтын ажил.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ